



Иргэний нисэхийн баримт бичигт
Safety & Security
гэдэг үгийг хэрхэн орчуулан,
хэрэглэсэн талаарх танилцуулга

Улаанбаатар хот



Тодорхойлолт

The Oxford dictionary describes the words in the following way:

Safety:

The condition of *being protected* from or unlikely to cause danger, risk or injury.

- ❖ Denoting something designed to prevent injury or damage.

From the Latin word 'salvus' - safe

Security:

The state of *being free from danger or threat*,

- ❖ The safety of a state or organizations against criminal activities such as terrorism, theft or espionage.

From the Latin word 'securus' – free from care

Oxford-ийн толь бичигт дараах утгаар тайлбарласан:

Аюулгүй байдал:

Санамсар болгоомжгүйгээр аюул, эрсдэл, эсхүл гэмтэл учруулахгүй байх, эсхүл түүнээс *хамгаалагдсан байх* нөхцөл.

- ❖ Аливаа зүйлийг гэмтэл, эсхүл хохирлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ.

Латин үг нь 'salvus' – аюулгүй байх

Аюулгүйн хамгаалалт:

Аюул, эсхүл заналхийллээс хамгаалагдсан байх нөхцөл,

- ❖ Улс, эсхүл байгууллагын аюулгүй байдлыг терроризм, хулгай, эсхүл тагнан турших зэрэг гэмт үйлдлээс хамгаалах арга хэмжээ.

Латин үг нь 'securus' – хамгаалагдсан байх



Тодорхойлолт

ICAO Doc 9713 ICAO Vocabulary / Олон Улсын Иргэний Нисэхийн тайлбар тольд:

Safety	Безопасность полётов	Нислэгийн аюулгүй байдал
Security <i>Safeguarding</i> civil aviation against acts of unlawful interference.	Безопасность / защита <i>Защита</i> гражданской авиации от актов незаконного вмешательства.	Аюулгүйн хамгаалалт Иргэний нисэхийг <i>хөндлөнгийн хууль бус үйлдлээс аюулгүй байхаар хамгаалах</i> ;
Safety - refers to freedom from the risk or occurrence of injury / loss from <i>natural cause</i> .		Аюулгүй байдал - гэж <i>дотоод хүчин зүйлээс шалтгаалсан</i> хохирол болон гэмтэл үүсгэх хэрэг явдал, эсхүл эрсдэлээс чөлөөтэй байх нөхцөлийг.
Security - refers to freedom from the risk or occurrence of injury / loss from the <i>intentional actions of mankind</i> .		Аюулгүйн хамгаалалт - гэж <i>хүний санаатай үйлдлээс учрах</i> хохирол болон гэмтэл үүсгэх хэрэг явдал, эсхүл эрсдэлээс чөлөөтэй байх нөхцөлийг.
Aviation safety means protection against all accidents, errors or unintentional defects in the design, construction, maintenance and operation of aircraft.		Нисэхийн аюулгүй байдал гэж агаарын хөлгийг зохион бүтээх, үйлдвэрлэх, үйлчилгээ хийх болон үйл ажиллагаатай холбоотой бүх осол, алдаа, эсхүл санаандгүй учрах гэмтлээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг.
Aviation security is the set of measures and resources implemented to prevent malicious, deliberate human intervention (terrorism) targeting aircraft, their passengers and crew members.		Нисэхийн аюулгүйн хамгаалалт гэж агаарын хөлөг, түүний зорчигч болон багийн гишүүдэд чиглэсэн хүний санаатай үйлдлээс (терроризм) хамгаалах зорилгоор хэрэгжүүлж байгаа цогц арга хэмжээ болон нөөцийг.



Монгол хэлний их тайлбар толь бичиг (<https://mongoltoli.mn>)

- ❖ **Аюулгүй байдлыг хангах** - осол аюулгүй байхаар бүх зүйлийг зохицуулах; (**safety**)
- ❖ **Аюулгүй ажллагааны зааварчилгаа** - хөдөлмөрийн үед хэрхэн **аюулгүй байдлыг** хангаж ажиллах тухай заасан дүрэм журам; (**safe operation**)
- ❖ **Аюулгүй байх** - хор хөнөөлгүй байх (**be safe**)
- ❖ **Аюулгүй байлгах арга техник** - аюулгүй байлгах арга, ур чадвар (**safety technique**)
- ❖ **Хамгаалалт** - амь нас, эд хөрөнгө, байгаль орчныг **гаднын** элдэв нөлөөнөөс сэргийлэн хамгаалах ажиллагаа; (**Security - Safeguarding civil aviation against acts of unlawful interference (Doc 9713)**)
- ❖ **Хамгаалагч** - хамгаалах үүрэг гүйцэтгэгч: бие хамгаалагч (хэн нэгний амь нас, аюулгүй байдлыг сахих үүрэгтэй хүн) (**Safeguarding, bodyguard**)

United nations security council	Совет безопасности ООН	НҮБ-ын Аюулгүйн зөвлөл
State Security Committee	Комитет государственной безопасности (КГБ)	Улсыг аюулаас хамгаалах хороо



Монгол улсын нэгдэн орсон конвенциуд

Бүх конвенцийн “safety”-г “аюулгүй байдал” гэж орчуулан МУ-ын хууль болгон УИХ баталжээ.

Гэрээний нэр / Name of the Agreement	Батлагдсан огноо	МУ нэгдэн орсон огноо	ТМЭ-ийн дугаар
Convention on the Safety of United Nations and Associated Personnel НҮБ-ын болон түүнтэй хамтран ажиллагсдын аюулгүй байдлын тухай конвенц	1994.12.09	2004.02.25	
Convention 155, Occupational Health and Safety Хөдөлмөрийн аюулгүй байдал , эрүүл ахуйн тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 155 дугаар конвенц, (түүний 164 дүгээр зөвлөмж)	1981.06.22	1999.02.03	Тусгай дугаар I боть
Convention (No. 176) concerning safety and health in mines Уурхай дахь аюулгүй байдал , эрүүл ахуйн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 176 дугаар конвенц	1995.06.22	2016.11.26	
Convention for the Suppression of Unlawful Acts Against the Safety of Civil Aviation Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай Монреалын конвенц	1971.09.23	1972.09.14	Тусгай дугаар IV боть
Convention for the Suppression of Unlawful Acts against the Safety of Maritime Navigation Далайн навигацийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай конвенц	1988.03.10	2006.02.20	ТМ 2005 оны №34
Protocol for the Suppression of Unlawful Acts against the Safety of Fixed Platforms located on the Continental Shelf Эх газрын хормойд суурилуулах төхөөрөмжийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай протокол	1988.03.10	2006.02.20	ТМ 2005 оны №34
International Convention for the Safety of Life at Sea Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай конвенц	1974.11.01	2001.12.24	Тусгай дугаар X боть
Protocol of 1988 relating to the international convention for the safety of life at sea, 1974 (SOLAS PROT 1978) Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай 1974 оны олон улсын конвенцын 1988 оны протокол	1988.11.11	2007.05.04	Тусгай дугаар X боть
Cartagena Protocol on Biosafety to the Convention on Biological Diversity Биологийн олон янз байдлын тухай конвенцын биоаюулгүй байдлын тухай Картагены протокол	2000.05.15	2003.07.22	Тусгай дугаар IX боть



Аюулгүй байдлын (**Safety**) талаар Чикагогийн конвенцийн албан орчуулгад

“Safety” гэсэн нэр томъёог 6 удаа “аюулгүй байдал”, 4 удаа “аюулгүй ажиллагаа” гэж орчуулсан байна.

3 bis зүйл

а) Хэлэлцэн тохиролцогч улс бүр нислэг үйлдэж буй иргэний агаарын хөлгийн эсрэг зэвсэг хэрэглэхээс түдгэлзэх, хүчээр буулгах тохиолдолд хөлөгт буй хүмүүсийн амь нас, **агаарын хөлгийн аюулгүй байдал** аюулд өртөхгүй байх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрөв.
(**safety of navigation of civil aircraft**)

9 дүгээр зүйл. Хориотой бүс

а) Хэлэлцэн тохиролцогч улс бүр цэргийн зорилго, эсхүл **нийтийн аюулгүй байдлын** шаардлагын үүднээс бусад улсын агаарын хөлгийг өөрийн нутаг дэвсгэрийн тодорхой бүс дээгүүр нислэг үйлдэхийг хориглож болох бөгөөд үүнтэй холбогдуулан тухайн нутаг дэвсгэрийг харьяалах улсын агаарын олон улсын тогтмол шугаманд үйлчилдэг агаарын хөлгийг хэлэлцэн тохиролцогч бусад улсын ижил төстэй агаарын хөлгөөс ялгаварлахгүй.
(**public safety**)

15 дугаар зүйл. Нисэх буудлын болон түүнтэй адилтгах хураамж

Хэлэлцэн тохиролцогч улс дахь үндэсний агаарын хөлөгт нээлттэй аливаа нисэх буудал бүхэн 68 дугаар зүйлд заасны дагуу хэлэлцэн тохиролцогч бусад бүх улсын агаарын хөлөгт адил нөхцөлөөр нээлттэй байна. Адил нөхцөл нь хэлэлцэн тохиролцогч улс бүрийн агаарын хөлөг агаарын навигацын хэрэгсэл, түүний дотор **агаарын навигацын аюулгүй**, түргэн шуурхай **байдлыг** хангах зорилгоор нийтэд зориулсан радио холбоо, цаг уурын албыг ашиглахад хамаарна. (**safety of air navigation**)



Аюулгүй байдлын (**Safety**) талаар Монгол Улсын хуульд:

Авто замын тухай хууль:

10.1.9. олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын ашиглалт, засвар, арчлалтын ажлыг нэгдсэн бодлого, мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, **замын хөдөлгөөний аюулгүй байдал**, ашиглалтын хэвийн нөхцөлийг хангуулах; (**safety, энэ хуульд “аюулгүй байдал” гэж 6, “аюулгүй ажиллагаа” гэж хэрэглээгүй**)

Авто тээврийн тухай хууль:

6.1.5. автотээврийн асуудлаар олон улсын үйл ажиллагаанд оролцох, улс хооронд тээвэрлэх ачаа, зорчигчдын хэмжээ болон **тээвэрлэлтийн аюулгүй байдал**, үйлчилгээний чанарын шаардлагын талаар холбогдох улстай тохиролцох; (**safety, энэ хуульд “аюулгүй байдал” гэж 4, “аюулгүй ажиллагаа” гэж хэрэглээгүй**)

Усан замын тээврийн тухай хууль:

12.1.3. усан замын тээврийн хэрэгслийн **хөвөлтийн аюулгүй байдлыг** хангах, тээвэрлэж байгаа ачааны бүрэн бүтэн байдал, зорчигчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах талаар удирдамж, заавар гаргах, түүнчлэн усан замын тээврийн хэрэгсэл дээр мөрдөх зааврыг гаргаж, мөрдүүлэх; (**safety, энэ хуульд “аюулгүй байдал” гэж 10, “аюулгүй ажиллагаа” гэж 3 удаа хэрэглэсэн**)

Төмөр замын тээврийн тухай хууль:

1.1. Энэ хуулийн зорилт нь төмөр замын тээврийн үйл ажиллагааны зарчмыг тодорхойлж, **хөдөлгөөний аюулгүй байдлыг** хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. (**safety, энэ хуульд “аюулгүй байдал” гэж 40, “аюулгүй ажиллагаа” гэж 5 удаа орсноос 3-ыг буруу хэрэглэсэн**)



Аюулгүй байдлын (**Safety**) талаар Монгол Улсын хуульд: (үргэлжлэл)

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль:

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт **замын хөдөлгөөний аюулгүй байдлыг** хангах эрх зүйн үндсийг тодорхойлж, холбогдох харилцааг зохицуулахад оршино. (**safety, энэ хуульд “аюулгүй байдал” гэж 99, “аюулгүй ажиллагаа” гэж хэрэглээгүй**)

Хөдөлмөрийн тухай хууль:

4.3. **Хөдөлмөрийн аюулгүй байдал**, эрүүл ахуй болон хөдөлмөрийн нөхцөлтэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулна. (**safety, энэ хуульд “аюулгүй байдал” гэж 7, “аюулгүй ажиллагаа” гэж 5 удаа хэрэглэсэн**)

Галт зэвсгийн тухай хууль:

11.5. Хот, суурин газарт **аюулгүй байдал** хангасан буудлага үйлдэх байгууламж /тир/-д спорт-сургалтын буудлага хийж болно. (**safety**)

Цөмийн энергийн тухай хууль:

3.1.3. “**цөмийн болон цацрагийн аюулгүй байдал**” гэж хүн ам, байгаль орчныг цацраг идэвхт бодис болон ионжуулагч цацрагийн бусад үүсгүүрийн нөлөөллөөс хамгаалах, цөмийн төхөөрөмж, цацрагийн үүсгүүрийн **аюулгүй ажиллагааг хангасныг**; (**safety**)

Галын аюулгүй байдал

1.1. Энэ хуулийн зорилт нь **галын аюулгүй байдлыг** хангах талаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эрх, үүрэг, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. (**safety**)



Хамгаалалтын талаар (**Security**) Монгол Улсын хуульд:

Төмөр замын тээврийн тухай хууль:

19.4. Суурь бүтэц эзэмшигч нь **төмөр замын объект, тээвэрлэж байгаа ачаа, тээш, ачаан тээшийг гэмт халдлагаас хамгаалах үүрэг бүхий харуул хамгаалалтын** болон хууль тогтоомж, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмийн биелэлт, **хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий дотоод хяналтын албатай** байна.

(**security - Цэрэгжүүлсэн хамгаалалтын алба, safety - дотоод хяналтын алба. Энэ хуульд “security” гэдэг ойлголтыг “хамгаалалт” гэдэг үгээр хэрэглэсэн**)

Гэрээт **харуул хамгаалалтын** тухай хууль:

3.1.1. **харуул хамгаалалт** гэж харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага гэрээний үндсэн дээр үйлчлүүлэгчийн эд хөрөнгө, объектыг **хамгаалах үйл ажиллагааг**; (**security, энэ хуульд “харуул хамгаалалт” гэж 75 удаа, “аюулгүй байдал” гэж хэрэглээгүй**)



Хамгаалалтын талаар (**Security**) Монгол Улсын хуульд: (үргэлжлэл)

Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль / State special **security** act:

1. Энэ хуулийн зорилт нь **төрийн тусгай хамгаалалт**, түүний хамрах хүрээ, **хамгаалалтыг** хэрэгжүүлэх байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, төрийн тусгай **хамгаалалтын үйл ажиллагаатай** холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

3. **Төрийн тусгай хамгаалалт** нь **аюулгүй байдлыг нь хангах зорилгоор** хуулиар төрийн тусгай хамгаалалтад авахаар тогтоосон төрийн байгууллага, тэдгээрийн зарим үйл ажиллагаа, албан тушаалтан, иргэний амь бие, ордон, өргөө, зориулалтын орон сууц, тээврийн хэрэгсэл, бусад зүйлийг **хамгаалахад чиглэсэн** мэргэжлийн болон бусад байгууллага, албан тушаалтны харилцан уялдаатай цогцолбор үйл ажиллагаа мөн. **(энэ хуульд “хамгаалалт” гэж 171 удаа, “аюулгүй байдлыг хамгаалах”, “аюулгүй байдлыг хангах” гэж 14 удаа, “ҮАБЗ” гэж 7 удаа хэрэглэжээ буюу security-г аюулгүй байдал гэж хэрэглээгүй байна)**

Хувийн хамгаалалтын тухай хууль:

3.1.1. **“хувийн хамгаалалт”** гэж хувийн хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд гэрээний үндсэн дээр үйлчлүүлэгчийн амь бие, эрүүл мэндийг **гэмт халдлагаас хамгаалахын** тулд энэ хуулиар зөвшөөрсөн үйл ажиллагаа явуулахыг; **(personal security, энэ хуульд “хамгаалалт” гэж 60 удаа, “аюулгүй байдал” гэж хэрэглээгүй)**



Safety & Security Иргэний нисэхийн тухай хуульд:

Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуулиудад “Safety - Аюулгүй байдал”, “Security - Хамгаалалт” гэж ихэвчлэн тайлбарласан байдаг боловч 1999 оны Иргэний нисэхийн тухай хуульд “Safety”, “Security”-ыг дараах байдлаар буруу ташаа хэрэглэсэн нь 1989 онд Монгол Улсын нэгдэн орсон Чикагогийн конвенци, Үндсэн хууль болон салбарын бусад хуулиудтай зөрчилдөж байна.

Иргэний нисэхийн тухай хууль:

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын агаарын зайд иргэний агаарын хөлгөөр нислэг үйлдэх, **нисэхийн аюулгүй ажиллагаа** болон **аюулгүй байдлыг** хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

3.1.13. “**нисэхийн аюулгүй ажиллагаа**” гэж нислэгийн үйл ажиллагаа болон түүнд хамаарах бусад үйл ажиллагааг хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгөд хохирол учруулахгүйгээр гүйцэтгэх нөхцөл байдал болон чадварыг; (**safety**)

3.1.17. “**нисэхийн аюулгүй байдал**” гэж нисэхийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалахтай холбогдсон цогцолбор арга хэмжээ; (**security гэж буруу хэрэглэсэн**)



Safety & Security Иргэний нисэхийн тухай хуульд: (үргэлжлэл)

“Safety” болон “security” гэдэг үгний орчуулгын алдаанаас болж нислэгийн аюулгүй байдлын цогц ойлголтыг дан ганц харуул хамгаалалтын функц мэтээр жижгэрүүлэн үгүйсгэн, нислэгийг аюулгүй гүйцэтгэх иргэний нисэхийн аюулгүй байдлын үндсэн чиг үүргийг бүрхэгдүүлснээр сүүлийн 20 жил ИНЕГ-ын үндсэн чиг үүрэг, удирдлагын мэргэжлийн чиг хандлага алдаж, салбар доройтож байна.

Model civil aviation safety act / Иргэний нисэхийн аюулгүй байдлын загвар хууль:

Civil aviation. The operation of any civil aircraft for the purpose of general aviation operations, aerial work, or commercial air transport operations.

Иргэний нисэх гэж ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа, агаараас гүйцэтгэх ажил, эсхүл арилжааны агаарын тээврийн үйл ажиллагааны зорилгоор гүйцэтгэдэг агаарын хөлгийн үйл ажиллагааг.



Safety & Security Иргэний нисэхийн тухай хуульд: (үргэлжлэл)

Аюулгүй байдал - Security (8)	Аюулгүй байдал - Safety (10)	Аюулгүй ажиллагаа - Safety (25)
<ul style="list-style-type: none">• нисэхийн аюулгүй байдал (7)• агаарын зайд аюулгүй байдлыг хангах эрх бүхий байгууллага (1)	<ul style="list-style-type: none">• аюулгүй байдлын зөвлөмж (1)• нислэгийн аюулгүй байдал (4)• агаарын хөлөг болон зорчигч, эд зүйлсийн аюулгүй байдал (1)• бүхээгт байгаа хүмүүсийн аюулгүй байдал (1)• аюулгүй байдлын дохио, тэмдэг (2)• агаарын зайн аюулгүй байдал (1)	<ul style="list-style-type: none">• нислэгийн аюулгүй ажиллагаа (11)• нисэхийн аюулгүй ажиллагаа (9)• агаарын хөлгийн аюулгүй ажиллагаа (2)• агаарын навигацийн аюулгүй ажиллагаа (1)• аюулгүй ажиллагааны шаардлага (1)• аюулгүй ажиллагааны стандарт (1)



Safety & Security Иргэний нисэхийн тухай хуульд: (үргэлжлэл)

3.1.13. **"нисэхийн аюулгүй ажиллагаа"** гэж нислэгийн үйл ажиллагаа болон түүнд хамаарах бусад үйл ажиллагааг хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгөд хохирол учруулахгүйгээр гүйцэтгэх нөхцөл байдал болон чадварыг; (**safety**)

3.1.17. **"нисэхийн аюулгүй байдал"** гэж нисэхийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалахтай холбогдсон цогцолбор арга хэмжээ; (**security**)

3.1.21. "шинжлэн шалгах" гэж гарч болзошгүй нислэг-техникийн хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээлэл цуглуулах, дүгнэлт хийх, түүнчлэн гарсан хэргийн шалтгааныг тогтоон **аюулгүй байдлын зөвлөмж** бэлтгэх үйл ажиллагаа; (**Safety order нь дан security биш, голчлон авиа компаниудад өгдөг safety зөвлөмж байдаг**)

6.1.2. иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга болон **Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын Улсын ерөнхий байцаагчийг** томилох, иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүрмийг батлах; (**safety + security-г бас харууцдаг**)

8.4.1. Чикагогийн конвенцийн Хавсралтуудад нийцсэн **аюулгүй ажиллагааны стандартыг** боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах буюу бүртгүүлэх, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих; (**safety + security-ийн дүрмүүд бас багтдаг**)

8.4.5. иргэний нисэхийн үйлчилгээний орлогыг хууль тогтоомжийн хүрээнд **нисэхийн аюулгүй ажиллагааг** хангах үйл ажиллагаанд зориулан захиран зарцуулах; (**safety, Одоогийн хуулиар аюулгүй байдал гэж тодорхойлогдсон security-г санхүүжүүлэх нь хууль бус болно**)



Safety & Security Иргэний нисэхийн тухай хуульд: (үргэлжлэл)

8.5. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь **нисэхийн аюулгүй ажиллагаанд** хамаарах бүрэн эрхийнхээ тодорхой хэсгийг Иргэний нисэхийн ерөнхий газрын ажилтан, томилогдсон байцаагч нарт гэрээний үндсэн дээр албан ёсоор шилжүүлэн гүйцэтгүүлж болно. Энэхүү гэрээнд ажилтны үүрэг, хариуцлагыг тодорхой тусгана. (**safety + security хариуцсан олон байцаагч байгаа нь хууль бус болно**)

8.7. Иргэний нисэхийн үйл ажиллагаанд тавих хяналтыг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын **Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын алба** бие даан хэрэгжүүлэх бөгөөд албаны дарга нь Улсын ерөнхий байцаагч байна. (**safety + НААХЗА-нд security хариуцсан олон байцаагч байгаа нь хууль бус болно**)

9 дүгээр зүйл. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт хариуцсан байцаагчийн бүрэн эрх (**safety + НААХЗА-нд security хариуцсан олон байцаагч байгаа нь хууль бус болно**)

11.2.4. нисэхийн салбарт гэрээгээр ажил гүйцэтгүүлэх, **нислэгийн аюулгүй байдлыг** хангах зорилгоор холбогдох байгууллагатай хамтран ажиллах, агаарын хөлгийн үзлэг, шалгалт хийх эрх олгох; (**safety**)

18 дугаар зүйл. Иргэний агаарын хөлгийн даргын бүрэн эрх

18.2.1. агаарын хөлөг болон түүний **бүхээгт байгаа хүмүүсийн аюулгүй байдлыг** хангах; (**safety**)

18.2.3. **нислэгийн аюулгүй байдалд** илт аюул тулгарсан тохиолдолд агаарын хөлөг болон түүний бүхээгт байгаа хүмүүсийн амь насыг аврах зорилгоор нислэгийн төлөвлөгөө болон нислэгийн удирдагчийн өгснөөс өөр шийдвэр гаргах; (**safety**)



Safety & Security Иргэний нисэхийн тухай хуульд: (үргэлжлэл)

18.2.4. нислэгийн үед агаарын хөлөгт дэг журам сахиулах, **нислэгийн аюулгүй байдалд** шууд заналхийлж байгаа этгээдийн үйлдлийг таслан зогсоох боломжтой бүх арга хэмжээ авах; (**safety**)

21.1. Агаарын хөлөг хөөрөх, буух, явгалах үед агаарын хөлгийн баг чиг баримжаагаа тогтооход зориулсан **аюулгүй байдлын дохио, тэмдгийг** Иргэний нисэхийн багц дүрэмд заасны дагуу аэродром, түүний орчинд байрлуулна. (**safety “ул харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээ”**)

22.1. Барилга байгууламж өмчлөгч буюу эзэмшигч нь агаарын хөлгийн нислэгийн **аюулгүй ажиллагааг** хангах зорилгоор уг барилга байгууламж дээр **аюулгүй байдлын дохио, тэмдгийг** Иргэний нисэхийн багц дүрэмд заасны дагуу байрлуулна. (**safety, “ул харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээ”**. 1 өгүүлбэрт 2 өөр утгаар хэрэглэсэн)

24.3. Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх замыг холбоо, навигацийн төхөөрөмжөөр **нислэгийн аюулгүй байдлыг** хангах түвшинд тоногдсон байна. (**safety**)

24.6. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба энэ хуулийн 24.5-д заасан агаарын хөлгийн тухай Монгол Улсын **агаарын зайд аюулгүй байдлыг хангах эрх бүхий байгууллагад** мэдэгдэж, агаарын хөлгийн нисэх багт зөрчлөө нэн даруй зогсоох буюу заасан газар хөлгөө буулгах шаардлага тавина. (**safety**)

26 дугаар зүйл. **Агаарын зайн аюулгүй байдлыг** хангах (**safety**)

Наймдугаар бүлэг. **Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны** зохицуулалт (**safety + security**)



Safety (Шинэ 47 ИНД-д 809 удаа)

Англи	Safety - аюулгүй ажиллагаа гэж хэрэглэвэл	Safety - аюулгүй байдал гэж хэрэглэвэл
work safety	хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа	хөдөлмөрийн аюулгүй байдал
passenger safety	зорчигчийн аюулгүй ажиллагаа	зорчигчийн аюулгүй байдал
safety of an aircraft operation	агаарын хөлгийн үйл ажиллагааны аюулгүй ажиллагаа	агаарын хөлгийн үйл ажиллагааны аюулгүй байдал
product safety	бүтээгдэхүүний аюулгүй ажиллагаа	бүтээгдэхүүний аюулгүй байдал
safety precautions	аюулгүй ажиллагааны анхааруулга	аюулгүй байдлын анхааруулга
interests of safety	аюулгүй ажиллагааны ашиг сонирхол	аюулгүй байдлын ашиг сонирхол
transport safety act	замын хөдөлгөөний аюулгүй ажиллагааны тухай хууль	замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль
public safety	олон нийтийн аюулгүй ажиллагаа	олон нийтийн аюулгүй байдал
safety harness for each seat	суудлын аюулгүй ажиллагааны бүс	суудлын аюулгүй байдлын бүс
endanger safety of any person	бусдын аюулгүй ажиллагаанд аюул учруулах	бусдын аюулгүй байдалд аюул учруулах
safety audit	аюулгүй ажиллагааны аудит	аюулгүй байдлын аудит
safety of persons and property	хүмүүс болон эд хөрөнгийн аюулгүй ажиллагаа	хүмүүс болон эд хөрөнгийн аюулгүй байдал
safe operation	аюулгүй ажиллагаа	аюулгүй ажиллагаа



Security (Шинэ 19 ИНД-д 595 удаа орсон)

Англи	Security - аюулгүй байдал гэж хэрэглэвэл	Security - аюулгүйн хамгаалалт гэж хэрэглэвэл
State special security	Төрийн тусгай аюулгүй байдал	Төрийн тусгай хамгаалалт
railway security	төмөр замын аюулгүй байдал	төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалалт
security agency	аюулгүй байдлын байгууллага	аюулгүйн хамгаалалтын байгууллага
cargo security incident	ачааны аюулгүй байдлын зөрчил	ачааны аюулгүйн хамгаалалтын зөрчил
security control	аюулгүй байдлын хяналт	аюулгүйн хамгаалалтын хяналт
security enhanced area	өндөржүүлсэн аюулгүй байдлын бүс	өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүс
security checks	аюулгүй байдлын шалгалт	аюулгүйн хамгаалалтын шалгалт
aviation security service organisations	нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээний байгууллага	нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага
security designated aerodrome	аюулгүй байдал тогтоосон аэродром	аюулгүйн хамгаалалттай аэродром
security designated navigation installations	аюулгүй байдал тогтоосон навигацгийн байгууламж	аюулгүйн хамгаалалттай навигацгийн байгууламж
security escort service	аюулгүй байдлын дагалдах үйлчилгээ	аюулгүйн хамгаалалт дагалдах үйлчилгээ
security officer	аюулгүй байдлын ажилтан	аюулгүйн хамгаалалтын ажилтан
security service	аюулгүй байдлын үйлчилгээ	аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ
security technique	аюулгүй байдлын арга техник	аюулгүйн хамгаалалтын арга техник



Analysis / Дүн шинжилгээ

Үндсэн хууль болон бусад хууль, тогтоомжид хэрэглэж байгаа “**Аюулгүй байдал**” гэсэн ойлголт нь “**safety**” бөгөөд батлан хамгаалах, нийгмийн дэг журмыг хангах гэдэг нь “**security**”-ийн ойлголт юм.


“**Safety**”-г “**аюулгүй ажиллагаа**” гэж томъёолсон нь нислэгийн аюулгүй байдлын цогц, түгээмэл ойлголтыг бүрхэгдүүлж, нислэгийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байна.

SAFETY

- GOALS:
- Prevent accidents and incidents
 - Improve work conditions
 - Reduce impact on health

SECURITY

- GOALS:
- Prevent misuse
 - Prevent terrorism
 - Protect equipment





Аюулгүй байдал, хамгаалалтын ялгаа / Safety vs Security

	Хамгаалалт / Security	Аюулгүй байдал / Safety
Тодорхойлолт / Definition	Гадны аюул, заналхийллээс хамгаалах / Protection against external threats	Дотоодын аюул, заналхийллээс хамгаалах / Protection against internal threats
Илрэх хэлбэр / Aspect	Биетээр илэрдэг / It is Physical Aspect	Сэтгэл зүй, хөдлөлөөр илэрдэг / It is an Emotional Aspect
Хүчин зүйл / Factor	Гадаад хүчин зүйл / External	Дотоод хүчин зүйл / Internal
Санаатай болон санаандгүй үйлдэл / Deliberate and Unintended	Санаатай аюул, заналхийлэл / Deliberate Threats	Санаандгүй аюул, заналхийлэл / Unintended Threats
Хамрах хүрээ / Coverage	Ерөнхий хамрах хүрээ / Broad Coverage	Чиглэсэн хамрах хүрээтэй / Narrow Coverage



Аюулгүй байдал, хамгаалалтын ялгаа / Safety vs Security

	Хамгаалалт / Security	Аюулгүй байдал / Safety
Шалтгаан	Зөрчил нь ихэвчлэн нэг эсхүл, бүлэг хүний гэмт хэргийн сэдэлтэй үйлдлээс шалтгаалдаг	Зөрчил нь ихэвчлэн хүрээлэн буй орчны нэгдлээс үүдэн хүнээс гарч байгаа гэмт хэргийн сэдэлгүй зан авираас шалтгаалдаг
	Ихэвчлэн хор хөнөөлтэй, төлөвлөсөн үйлдэл	Ихэвчлэн төлөвлөгдөөгүй, ховор тохиолддог боловч хор хөнөөлтэй үйлдэл
	Ихэвчлэн хүссэн үр дагаварт хүрэх зорилгоор хийдэг санаатай үйлдэл	Ихэвчлэн хүссэн үр дагавар болон санаандгүй зөрчил гаргах зорилгогүйгээр хийдэг санамсар болгоомжгүй үйлдэл
Аюул заналхийлэл	Аливаа этгээдийн гаднаас болон дотроос хийх аюул заналхийлэл	Аливаа этгээдийн дотроос хийх аюул заналхийлэл
	Таньж тогтоох, урьдчилан мэдэж, тооцоолох боломжгүй заналхийлэл	Таньж тогтоох, урьдчилан мэдэж, тооцоолж болохуйц аюул
Хохирол	Ихэвчлэн биет өмч хөрөнгө болон мэдээлэлтэй холбоотой хохирол	Хүний гэмтэл / үхэл болон салбарын найдвартай ажиллагаатай холбоотой хохирол
Орчны нөлөө	Нийгмийн бүтэц, эдийн засгийн нөхцөл, хууль дагаж мөрдөх ёс суртахуунаар дамжин тухайн улсын нийгмийн төлөв байдлыг илэрхийлдэг	Хүн болон нийгмийн төлөв байдлын нөлөөнөөс гадна, бодит болон хүрээлэн буй орчны нөхцлөөс шалтгаална
Хамаарал	Бүх байгууллагад хамааралтай	Аж үйлдвэр болон тээврийн салбарт илүү хамааралтай
Урьдчилан тодорхойлох боломж	Аюул заналхийллийг урьдчилан тодорхойлох боломж асар бага	Аюулыг урьдчилан таамаглаж, тодорхойлох боломжтой



Нийтлэг ойлголт

❖ **Safety** – Аюулгүй байдал;

❖ **Security** – Аюулгүйн хамгаалалт / харуул хамгаалалт

гэж томъёолох нь Монгол улсын Үндсэн хууль болон бусад хууль, тогтоомжтой нийцэх бөгөөд утга санаа бүрхэгдэхгүй, иргэний нисэхийн нислэгийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүрэг бүхий үйл ажиллагааг улам тодорхой, үр дүнтэй, аюулгүй болгох ач холбогдолтой.

Safety болон ***Security*** үгний ялгааг зөв ойлгосноор олон хүний амь насыг аврах нөхцөл бүрдэнэ.

Understanding the Difference of Safety vs. Security, May Soon Save Lives.